



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2013 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А-131

Улаанбаатар хот

“Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банкны (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А-122 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын 5.4 дэх заалтыг дараах байдлаар өөрчилсүгэй.

5.4 Банк өмнө нь олгосон орон сууцны ипотекийн зээлийг энэ журмын 4.2.2-т заасан зориулалттай эхлэлийн санхүүжилтийн эх үүсвэрээр дахин санхүүжүүлнэ. Зээлийг дахин санхүүжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

5.4.1 Дахин санхүүжилтийн хэмжээ нь өмнө олгосон орон сууцны ипотекийн зээлийн өрийн үлдэгдлээс ихгүй байх;

5.4.2 Дахин санхүүжилт хүсэгч зээлдэгч нь зээлийн нөхцөлийн болон зээлдэгчийн шалгуур, барьцаа хөрөнгийн шалгуурыг тус тус хангасан байх;

5.4.3 Дахин санхүүжилтээр олгож байгаа орон сууцны ипотекийн зээл нь бүрэн хорогдох, тогтмол хүүтэй байх;

5.4.4 Энэ журмын 3.2.3, 3.2.4-д заасны дагуу олгосон орон сууцны ипотекийн зээлийн өрийн үлдэгдлийг энэ журмын дагуу олгох зээлийн эх үүсвэрээр дахин санхүүжүүлэхгүй;

5.4.5 Нийтийн зориулалттай орон сууцны ипотекийн зээлээс бусад ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэхгүй.

2.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

14 0979